



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 51440

Улаанбаатар хот

Н.Дуламсүрэнд тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.14-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу, эрүүл мэндийн байдал, эмчилгээ хийлгэх шаардлага, гаргасан хүсэлтийг нь харгалзан хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Нэгсээбаатарын Дуламсүрэнд 1.000.000 /нэг сая/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Мөнгөн тусламжийг нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас бодож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000000697